

**МУИС-ийн ХШУИС-ийн Хүрээлэн буй орчин, ойн инженерчлэлийн тэнхимийн  
2022-2023 оны хичээлийн жилийн хөтөлбөрийн дэд хорооны хурлын протокол  
(№4)**

**Хугацаа:**

Хурал 2023 оны 05-р сарын 31-ны 14:00 цагт эхэлж 14:40цагт дуусав.

**Ирц:**

Хуралд хөтөлбөрийн дэд хорооны ахлагч проф. Ч.Сономдагва, нарийн бичиг дэд проф Д.Батсүрэн, гишүүд проф. О.Алтансүх, дэд проф Ц.Соёл-Эрдэнэ, доктор П.Оюунбат нар оролцов. Хөтөлбөрийн дэд хорооны хурлын ирц 71.4 % байв.

**Байршил:**

МУИС-ийн хичээлийн 3-р байр 217 тоот өрөөд болов.

**Хэлэлцэх асуудал:**

Европын Холбооны ERASMUS+ хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Энэтхэг ба Монгол улсын хот суурин газрын уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадвар, түүнд дасан зохицох байдал: Ногоон ба цэнхэр дэд бүтэц, байгальд түшиглэсэн шийдлийг дэмжихэд чиглэсэн сургалтын хөтөлбөр, чадавх бэхжүүлэлт, мэдээлэл харилцааны технологи ашиглалт, оролцогч талуудын хамтын ажиллагаа – URGENT” төслийн хүрээнд шинээр болон шинэчлэн боловсруулсан 5 хичээлийн үр дүнг хэлэлцэж, сургалтад ашиглаж болох эсэх тухай дүгнэлт гаргах.

**Хурлын явц:**

**Ч.Сономдагва:** Тэнхимийн хөтөлбөрийн хорооны ээлжит хурал эхлэх байна. Өнөөдрийн хурлыг Тэнхимийн хөтөлбөрийн хорооны нарийн бичгийн дарга Д.Батсүрэн удирдан явуулах уу?

**Д.Батсүрэн:** Өнөөдрийн тэнхимийн хөтөлбөрийн хорооны хурлаар О.Алтансүх багшийн удирдан хэрэгжүүлж байгаа Европын Холбооны ERASMUS+ хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Энэтхэг ба Монгол улсын хот суурин газрын уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадвар, түүнд дасан зохицох байдал: Ногоон ба цэнхэр дэд бүтэц, байгальд түшиглэсэн шийдлийг дэмжихэд чиглэсэн сургалтын хөтөлбөр, чадавх бэхжүүлэлт, мэдээлэл харилцааны технологи ашиглалт, оролцогч талуудын хамтын ажиллагаа – URGENT” төслийн хүрээнд шинээр болон шинэчлэн боловсруулсан 5 хичээлийн үр дүнг хэлэлцэж, сургалтад ашиглаж болох эсэх тухай дүгнэлт гаргах ёстой байгаа. Проф О.Алтансүх багш та 5 хичээлийнхээ танилцуулга хийх үү?

**О.Алтансүх:** Таван хичээлийн хөтөлбөрүүдийг бүгдийг нь нэг доор танилцуулаад дараа нь хэлэлцээд явах уу? эсвэл тус тусад нь танилцуулаад явах уу?

**Ч.Сономдагва:** Хичээл тус бүрийн хөтөлбөрийг тус тусад хэлэлцээд явсан дээр байхаа.

**О.Алтансүх:** Төслийн хүрээнд хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх болон шинээр боловсруулах ажлыг хийхдээ нийт 23 алхмаар дамжуулан хийдэг. Энэ ажлын

хүрээнд шинэчлэн боловсруулсан хичээлээс хамгийн эхний хичээл бол бакалаврын түвшний “Хүрээлэн буй орчны судалгаанд зайнаас тандан судлал ба газарзүйн мэдээллийн системийн хэрэглээ” ENVI 402-3кр хичээл байгаа юм. Энэ хичээл нь шинэчлэгдэж бүрэн цахим хичээл болгож МУИС-ийн цахим сургалтын платформ болох <https://online.num.edu.mn/> байршуулсан. Энэ жил туршилтаар шинэчилсэн хичээлээ орсон байгаа. Тухайн хичээлийн дараа оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг авсан бөгөөд хичээлийг судалсан оюутнуудын сэтгэл ханамжийн үнэлгээ 86% тай байсан. Тухайн хичээлийн шинэчлэлийг хийхдээ МУИС-ийн журмын дагуу анх 2021 онд тэнхимийн хурлаар ороод процедурын дагуу явсан бөгөөд нийт 23 алхмын дагуу явцын болон дотоодын хяналт үнэлгээ хийгдэж явсан. Хамгийн гол анхаарах ёстой зүйл бол хамтран ажиллаж байгаа байгууллага буюу ХААИС, тухайн үед ХИС одоо МУИС-ийн Ховд аймаг дэх салбар сургуулиас санал авах бусад мэргэжлийн байгууллагууд болон ажил олгогчдын санал, тэнхимээс томилогдож ажилласан багш нарын санал мөн Европын холбооны төсөл дээр ажиллаж байгаа экспертүүдийн санал зэрэг нийт 4 саналын хүрээнд эцэслэгдэн боловсрогдож одоо та бүхий гар дээр байгаа сүүлийн хувилбар бий болсон байгаа. Хамгийн сүүлд тэнхимийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж албан болон албан бус сургалтад ашиглах боломжтой тодорхойлон ашиглаж явах нь гол үр дүн юм. Тухайн хичээлүүдийг заасны дараа судалсан оюутнуудаас санал авч сайжруулалт хийгээд явж байх ёстой байгаа.

**Ч.Сономдагва:** Энэ хичээл нь манай өмнөх сургалтын төлөвлөгөөнд болон шинэчлэгдэж байгаа сургалтын төлөвлөгөөнд “Заавал судлах” хичээлийн жагсаалтад байдаг хичээл байгаа юм. Энэ хичээл нь нэр болон индекс өөрчлөгдөөгүй зөвхөн тухайн хичээлийн агуулаг нь л өөрчлөгдсөн байгаа юм байна. Тухайн хичээлийн агуулаг болон шинэчлэл сайжруулалт хийгдсэн байна уу гэдэг л үнэлэлт дүгнэлт өгөөд явах нь дээр юм. Харин анхаарах ёстой нэг зүйл байна. Тухайн хичээлийг орохдоо хосолсон хэлбэрээр ороод явах нь дээр байх. Яагаад гэвэл энэ хичээл нь компьютерын лабораторид хичээллэх шаардлага гардаг тул хосолсон байдлаар ороод явах дээр юм. Тухайн хичээлийн шинэчлэлийг мэдэж байгаа тул шууд дараагийн хичээлийн танилцуулгаа хийх үү?

**О.Алтансүх:** Хоёр дэх хичээл бол “Тогтвортой хөгжил” ENVI 502-3кр хичээл байгаа. Энэ хичээлийг бакалавр болон магистрын түвшин үзэхэд тохиромжтой болгож агуулгыг нь өргөтгөж сайжруулсан байгаа.

**Ч.Сономдагва:** Хуучин хөтөлбөрийн аль хичээл билээ?

**Д.Батсүрэн:** Хуучин хөтөлбөрийн “Уур амьсгал ба тогтвортой хөгжил хичээл” мөн үү?

**О.Алтансүх:** Тиймээ, тэгээд одоо бол дараах агуулгатай болсон байгаа. Нэг зүйлийг хэлэхэд тухайн хичээлийн хөтөлбөрийг боловсруулсан багш нь энэ хичээлийг өмчлөх, заавал заана гэсэн үг бишээ. Үүнийг бол тэнхимийн хүрээнд шийдэх ёстой. Нээлттэй тавиад тухайн хичээлийг орох саналаа өгсөн багш нь ороод явдаг шиг ч байж болох байгаа. Гэхдээ бид төсөл хэрэгжүүлэхэд санхүүжүүлэгч талаас тавьж



байгаа шаардлагад нийцүүлэн манай тэнхимийн багш нараас өөр багш нар боловсруулсан байгаа.

**Ч.Сономдагва:** Энэ хичээлийг шинэ сургалтын төлөвлөгөөнд бакалавр болон магистрын түвшинд үзэх дундын хичээл болгож оруулсан таван зуу индекстэй хоёр хичээлийн нэг нь энэ хичээл байгаа. Нэг асуудал байна. Энэ хичээлийн бакалавр дэх хичээлийг Н.Оюунчимэг багш орж байсан байгаа. Гэтэл боловсруулсан хүний дотор Н.Оюунчимэг багш байхгүй байх юм. Хойд хэсэг дээр байх хичээл заах багшийн мэдээлэл дээр Н.Оюунчимэг багшийн мэдээллийг нэмж өгөх хэрэгтэй байна. Цаашид тухайн хичээлийг заах боломжийг нь олгох хэрэгтэй юм.

**О.Алтансүх:** За ойлголоо.

**Ч.Сономдагва:** За Гурав дэх хичээлээ танилцуулаад явах уу?

**О.Алтансүх:** Гурав дэх хичээл бол “Хүрээлэн буй орчны менежмент” ENVI 801 3-кр цаг бүхий докторын хичээл байгаа. Энэ хичээл нь “Хүрээлэн буй орчны бодлого, менежмент” ENVI 801 3-кр хичээлийг шинэчилсэн байгаа. Уг хичээлийг өнгөрсөн жил Б.Ариунсанаа багш орсон байгаа.

**Ч.Сономдагва:** Энэ хичээлийг өмнө нь Д.Доржготов, Б.Оюунсанаа багш нар орж байсан хичээл байгаа юм.

**Д.Батсүрэн:** Энэ хичээлийг дээрх хоёр багштай бид гурав орж байсан. Дараа нь Б.Ариунсанаа багштай нийлж ордог болсон хичээл мөн байна.

**Ч.Сономдагва:** Энэ хичээл дээр ямар өөрчлөлт хийгдсэн юм бэ?

**О.Алтансүх:** Энэ хичээл дээр агуулгын өөрчлөлт хийгдсэн.

**Ч.Сономдагва:** Энд нэг асуудал байна. Ахлах багш ахисан түвшин хичээл орох асуудалтай. Ер нь бол профессор болон дэд профессор багш нар ахисан түвшинд ордог байвал сайн байгаа юм. Тиймээс өмнө орж байсан профессор юм уу дэд профессор багш нарыг хичээл заах багш нарын жагсаалтад нэмээд хамт оруулаад явсан дээр шүү.

**Д.Батсүрэн:** Энэ хичээлийг би 2-3 жил заасан хичээл байгаа юм. Миний докторын түвшин ордог үндсэн хичээл байгаа юм.

**О.Алтансүх:** Энэ хичээлийг заах багшийн жагсаалтад Д.Батсүрэн багшийн нэрийг оруулаад хамтран хичээлээ заагаад явж болно болно.

**Ч.Сономдагва:** За тэгвэл Д.Батсүрэн багшийг оруулаад явчих уу.

**О.Алтансүх:** За тэгье. Дараагийн танилцуулах 4 дэх хичээл бол “Хотын логистик” ENEN 301 3-кр хичээл байгаа. Хүрээлэн буй орчны инженер хөтөлбөрт орж байсан хичээл байгаа юм Ц.Соёл-Эрдэнэ багш багаа юм чинь бас саналаа хэлээд явах байх.

Тухайн хөтөлбөрт бол байгаа шинэчлэгдэж байгаа хөтөлбөрөөс хасагдсан байх юм. Гэхдээ албан бус сургалтад ашиглаад явах боломжтой гэж үзэж байна.

**Ч.Сономдагва:** Ямар индекстэй байгаа билээ?

**О.Алтансүх:** ENEN индекстэй хичээл байгаа.

**Ц.Соёл-Эрдэнэ:** Албан бус сургалт гэж ямар сургалтыг хэлж байгаа билээ?

**О.Алтансүх:** Албан болон Албан бус сургалт гэж хоёр үндсэн хэлбэртэй байгаа.

Нэгдүгээр нь албан сургалт гэдэг нь хөтөлбөрөөр баталгаажин одоо бидний зааж байгаа сургалт буюу тухайн хөтөлбөрт элсэж орсон оюутан үздэг сургалт юм.

Хоёрдугаарт нь Насан туршийн боловсролыг дэмжих зорилгоо хэн ч үзэж болохоор сургалт юм. Эсвэл албан болон албан бус сургалтад хослуулан ашиглах байдлаар явах нь зөв гэж бодож байна.

**Ч.Сономдагва:** Үүнийг танай хөтөлбөр дээр оруулах боломжгүй юм уу?

**Ц.Соёл-Эрдэнэ:** Шинэ хөтөлбөр дээр оруулж ирэхээр тусгаж оруулсан юм. Гэтэл хөтөлбөрийн хорооны хурал дээр хасагдаад явсан байсан.

**Ч.Сономдагва:** Эсвэл цаашдаа магистрын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд сайжруулалт хийгээд Магистрын сонгон судлах хичээл болгоод явах ч юм уу? тэнд тусгаж өгвөл ямар вэ?

**О.Алтансүх:** Болно болно.

**Ч.Сономдагва:** О.Алтансүх багш та “Байгаль хамгаалах хөтөлбөр”-ийн зохицуулагч тул хөтөлбөр шинэчлэлийн хүрээнд уг хичээлийг тусгаад явж болно байх гэж бодож байна.

**О.Алтансүх:** За тэгье, ойлголоо.

**Ч.Сономдагва:** Албан бус сургалтад оруулах гэж байхаар Магистрын хөтөлбөрийн шинэчлэл дээрээ оруулаад явах, мөн МУИС-ийн Хот төлөвлөлтийн ангид оруулах гээд өөр хөтөлбөрүүд дээр судлаад явах боломжийг нь хангаад явуулсан дээрээ.

**О.Алтансүх:** Индекс өөрчлөгдөхгүй гэсэн үг үү?

**Ч.Сономдагва:** Магистрын хөтөлбөрийн шинэчлэл дээр аль хөтөлбөрт нь байх вэ гэдгээс нь хамаараад индекс өөрчлөөд шинэчлээд явсан нь дээрээ.

**О.Алтансүх:** За ойлголоо.

**Ч.Сономдагва:** За энэ хичээлийг болгоё.

**О.Алтансүх:** Дараагийн хичээл бол “Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” ENVI 802 3-кр бүхий докторын түвшний хичээл байгаа. Өмнө нь Ч.Сономдагва багш ордог байсан хичээл байгаа.



**Ч.Сономдагва:** За энэ хичээлийн агуулгыг гаргаад ирээч. Миний зааж байсан хичээлийг надаас асуугаагүй өөрчлөөд явсан байгаа юм.

**О.Алтансүх:** Энэ хичээлийг мөн түрүүний ярьсны дагуу дараагийн магистрын хөтөлбөрийн шинэчлэл дээр магистр болон докторын түвшин дундын байдлаар үздэг хичээл болгоод явах уу? Манай докторын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүд бол харьцангуй сайн хийгдсэн байдаг.

**Ч.Сономдагва:** Хүрээлэн буй орчин судлалын докторын хөтөлбөр бол харьцангуй сайн хийгдсэн хөтөлбөр тул өөрчлөлт нэг их орохгүй болчих байхаа.

**О.Алтансүх:** Тиймээ. Доктор дээр түрүүний Д.Батсүрэн болон Б.Ариунсанаа багш хоёрын хамт ордог “Хүрээлэн буй орчны менежмент” хичээлээс бусдыг нь нэг их өөрчлөөд дэмий тул энэ танилцуулж байгаа “Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” хичээлийг магистрын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд байгаль хамгаалал нэрийг нь хасаад “Тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” гэдэг нэрээр нь явах нь зөв юм байна. Тэгээд хөтөлбөрийн хороо болон хариуцсан багш нартай нь ярилцаж байгаад заавал судлах уу, сонгон судлах хичээл болгох уу гэдгээ шийдсэн гээд гэж бодлоо.

**Ч.Сономдагва:** За бараг тэр нь оновчтой байхаа. Боловсруулсан багшийн чиглэлийг хархаар тусгай хамгаалалттай газар нутгийн чиглэлийн хүн байна. Тэгэхээр энэ хичээлийн нэр болон индекс дээр анхаарал хандуулаад л шинээр боловсрогдох магистрын хөтөлбөрт оруулаад явахад асуудалгүй юм.

**П.Оюунбат:** Магистрын түвшинд үзнэ гэсэн үг үү тэ?

**О.Алтансүх:** Тиймээ индексийг нь 600 тай болгоод магистрын түвшин оруулна гэсэн үг. Шинэ хичээлийн жилээс магистрын хөтөлбөрийн шинэчлэл дээр орж ирнэ гэсэн үг юм.

**Ч.Сономдагва:** Тиймээ. Энэ хичээл нь цахим хичээл тул бусад мэргэжлийн хөтөлбөрүүдэд тусгаад явуулах юм бол сайн байна шүү.

**Ч.Сономдагва:** За танилцуулсан 5 хичээлийн эхний 3 н хичээл нь ямар ч асуудал алга. “Хотын логистик” болон сүүлд танилцуулсан “Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” гэх хичээлийг магистрын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд нэр болон индексийн шинэчлэл хийгээд оруулаад явъя. Дээрх саналыг дэмжиж байна уу?, дээрх саналаас өөр саналтай хүн байна уу? За байхгүй байна. Бүх багш нар дээрх саналуудыг дэмжиж байна уу? Та бүхэн саналаа өгнө үү?

Бүх гишүүд дээрх саналыг 100% дэмжив.


**Шийдвэрлэсэн нь:**

1. “Хүрээлэн буй орчны судалгаанд зайнаас тандан судлал ба газарзүйн мэдээллийн системийн хэрэглээ” ENVI 402, “Тогтвортой хөгжил” ENVI 502 (ENVI 312 + ENVI 618), “Хүрээлэн буй орчны менежмент” ENVI 801 гэсэн гурван хичээлийн шинэчлэлийг шууд сургалтад ашиглах саналыг 100% -ийн саналаар дэмжив.

2. “Хотын логистик” ENEN 301, “Байгаль хамгаалал ба тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент” ENVI802 хичээлийг магистрын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд нэр болон индексийг өөрчлөн сургалтын хөтөлбөрт оруулж цаашид сургалтад ашиглах саналыг 100% -ийн саналаар дэмжив.
3. Дээрх хичээлүүдийн шинэчлэл, сайжруулалтыг цаашдаа МУИС-ийн сургалтын хөтөлбөрт ашиглах саналыг 100% -ийн саналаар дэмжив.

Протокол хөтөлсөн:


Хөтөлбөрийн дэд хорооны н.б.д.



дэд профессор Д.Батсүрэн

Хянасан:

Хөтөлбөрийн дэд хорооны ахлагч



профессор Ч.Сономдагва





Co-funded by the  
Erasmus+ Programme  
of the European Union



**URBAN RESILIENCE AND ADAPTATION FOR INDIA AND MONGOLIA:**  
Curricula, Capacity, ICT and Stakeholder Collaboration to Support Green & Blue Infrastructure and Nature-Based Solutions

**Minutes of the Program Committee Meeting of the Department of Environmental and Forest  
Engineering, National University of Mongolia  
2022-2023 Academic Year, #4**

**Duration:**

The meeting started at 14:00 on May 31, 2023 and ended at 14:40.

**Attendance:**

In the meeting, the Head of the program committee, Prof. Ch.Sonomdagwa, the secretary Assoc.prof. D.Batsuren, members Prof. O.Altansukh, Assoc.prof. Ts.Soyol-Erdene, a representative of employers, PhD P.Oyunbat were participated. The program committee meeting attendance was 71.4%.

**Venue:**

The meeting was held in room 217 of Building 3, the National University of Mongolia.

**Agenda:**

“Urban Resilience and Adaptation for India and Mongolia: curricula, capacity, ICT and stakeholder collaboration to support green & blue infrastructure and nature-based solutions - URGENT” project, funded by ERASMUS+ CBHE program of European Union has been implementing since 2021. Within the scope of the project, a total of 2 e-courses have been developed, and 3 e-courses have been revised, they were discussed and accredited whether they meet the requirements of the university and the project, and concluded whether they can use for study or not.

**Decision:**

1. The following 3 e-courses are met the requirements of the university and the project, and concluded to use for the university study programs.
  - ~ Application of RS and GIS to environmental research, ENVI402 at the bachelor level.
  - ~ A new index ENVI502 assigned to an e-course “Sustainable development”, and can use at the bachelor and master levels.
  - ~ Environmental management, ENVI801 at the doctoral level.
2. The following 2 e-courses are met the requirements of the university and the project, and concluded to use for the university study programs. In next year, curriculums of master level will be updated. In that time, they need to change the course name and the index.
  - ~ Urban logistics and environment, ENEN301 at the master level.
  - ~ Nature conservation and protected area management, ENVI802 at the master level.
3. All 5 e-courses are qualified and accredited at the department.

**Signed and stamped by:**

Associate Professor D.Batsuren, Secretary of the Program Committee

Professor Ch.Sonomdagwa, Head of the Program Committee

*Erasmus+ CBHE project: Urban Resilience and Adaptation for India and Mongolia:  
curricula, capacity, ICT and stakeholder collaboration to support green & blue infrastructure and nature-based solutions*